



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 4/192

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Оросын Холбооны улсаас хүмүүнлэгийн тусламжаар ирсэн 100 тн тэжээлийн будаа (овьёос) Сэлэнгэ аймгаас татан авах тээврийн зардал, будаа шуудайлах шуудай авах хөрөнгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардалд шаардагдах нийт 4,850,000 (Дөрвөн сая найман зуун тавин мянга) төгрөгийн зардлыг Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын
гаар сарын 24-ны өдрийн
захирамжийн

[illegible]

-----oOo-----